



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/414

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлэгт “Эмийн эмчилгээг зохицуулах хороо” ажиллах журмыг нэгдүгээр, эмнэлгийн эмийн хэрэглээний мэдээний маягтыг хоёрдугаар, антибиотик эмийн хэрэглээний мэдээний маягтыг гуравдугаар, антибиотик мэдрэг чанар тодорхойлсон дүнгийн маягтыг дөрөвдүгээр, “Эмийн эмчилгээг зохицуулах хороо” -ны үйл ажиллагааны тайлангийн маягтыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-г шинэчлэн зохион байгуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж, шаардагдах зардлыг жил бүр байгуулагынхаа төсөвт тусган ажиллахыг тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, 40- өөс дээш ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, 40-өөс дээш ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Эмийн эмчилгээг тасралтгүй, жигд, оновчтой төлөвлөж, эмчилгээний өндөр идэвхитэй, чанарын баталгаатай эмийн сонголт, хангамжийг сайжруулах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, сувилал, хувийн эмнэлгийн дарга нарт үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж , мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Н.Гэрэлт-Од/-т даалгасугай.
6. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 336 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081572

Эрүүл мэндийн сайдын 2019 оны ...
сарын 07 өдрийн А/444 тушаалын
нэгдүгээр хавсралт

“ЭМИЙН ЭМЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРОО”-НЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1 Эмнэлэгт эмийн эмчилгээг зохицуулах хороо (цаашид “хороо” гэх) болон антибиотикийн дэд хорооны ажиллах бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагааны эрх, үүргийг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Хорооны зорилго нь эмнэлэгт “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх, нянгийн тэсвэржилтийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авах, эмчилгээний өндөр идэвхитэй, чанарын баталгаатай эмийн сонголт, түгээлт, хадгалалт, хэрэглээ, хүртээмжид хяналт тавих, эмийн эмчилгээг тасралтгүй, жигд, оновчтой, үр ашигтай болгох, нянгийн тэсвэржилт, мэдрэг чанарын зүй тогтолыг тандах, судлах, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгчид эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.
- 1.3 Хороо нь “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”, “Эрүүл мэндийн тухай” хууль, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичиг, бусад хууль тогтоомж, стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.
- 1.4 Хороог тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, 40-өөс дээш ор бүхий хувийн хэвшлийн эмнэлэгт зохион байгуулна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

- 2.1 Эмнэлгийн хүчин чадал, хүний нөөцийн хангамжаас хамааран хорооны бүрэлдэхүүн нь дараах гишүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - 2.1.1 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (ор бүхий)-т эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, эмнэлзүйн эм судлаач, эмнэлзүйн эм зүйчид, чанарын албаны дарга, нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, халдвар судлаач эмч, сувилахуйн арга зүйч, санхүүгийн асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтан зэрэг (9-оос доошгүй) гишүүдээс бүрдэнэ.
 - 2.1.2 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газарт эмчилгээ эрхэлсэн дарга, эмнэлзүйн эм судлаач, эмнэлзүйн эм зүйчид, чанарын албаны дарга, сувилахуйн арга зүйч нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, санхүүгийн асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтан зэрэг (7-оос доошгүй) гишүүдээс бүрдэнэ.

2.1.3 40-өөс дээш ор бүхий хувийн эмнэлэгт эмчилгээ эрхэлсэн дарга, эмнэлзүйн эм судлаач, эмнэлзүйн эм зүйч, чанарын менежер, нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, сувилахуйн арга зүйч зэрэг (5-аас доошгүй) гишүүдээс бүрдэнэ.

2.2 Хороог эмчилгээ эрхэлсэн орлогч дарга тэргүүлэх бөгөөд нарийн бичгийн даргаар эм зүйн албаны дарга ажиллана.

2.3 Хороо нь эмнэлгийн даргаар батлуулсан ажлын нарийвчилсан төсөв, төлөвлөгөөтэй байж, үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүр төсөвтөө тусган, санхүүжүүлнэ.

2.4 Хороо нь дэргэдээ "Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг өөрийн эмнэлгийн нөхцөлд тохируулан боловсруулж, хэрэгжүүлэх баг" буюу антибиотикийн дэд хороотой байна.

2.5 Антибиотикийн дэд хорооны бүрэлдэхүүнд халдвар судлаач эмч, нян судлаач эмч, эмнэлзүйн эм зүйч болон чанарын менежер, сувилахуйн албаны төлөөлөл ажиллана.

Гурав. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны эрх, үүрэг

3.1 Хороо нь дараах эрх эдэлнэ.

3.1.1. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний заавар боловсруулахад санал өгөх;

3.1.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ эм нэвтрүүлэх, эмчилгээнд хэрэглэж байсан эмийг ижил үйлчилгээтэй эмээр солих, зарим эмийн хэрэглээнд нас, тунгийн хязгаарлалт хийх, гаж нөлөө нь тогтоогдсон, эмчилгээний үр дүнгүй эмийг эмчилгээнээс хасах зэргээр Хүний эмийн зөвлөлд асуудал дэвшүүлэх;

3.1.3 Тендерийн баримт бичиг боловсруулах, бэлтгэх болон үнэлгээний хороонд гишүүнээр оролцох;

3.1.4 Тендерээр худалдан авч байгаа эмийн сонголт, чанар, зарцуулалт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг үнэлэх ;

3.1.5 Эмийн эмчилгээний тасалдлыг хянах, эмчийн заавраар хэвтэн эмчлүүлэх үед үйлчлүүлэгчээр авчруулж эмчилгээнд хэрэглэсэн эмийг эргүүлэн төлөх асуудлыг эмнэлгийн удирдлагад дэвшүүлэх;

3.1.6 Нянгийн тэсвэржилт, мэдрэг зүйн тогтлыг судлан тандахад эмч, мэргэжилтэнг татан оролцуулах;

3.1.7 Нян эмэнд тэсвэржихээс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг таслан зогсоох, эрсдэлийг бууруулах, анхаарал татаж буй нянгийн эмнэлзүйн сорилт бүхий хяналтыг сайжруулах талаар салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан мэдээлэл солилцох;

3.1.8 Эмнэлэгт эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;

3.1.9 Эмийн чанар, хангамж, хэрэглээтэй холбогдсон аливаа зөрчлийг арилгуулахаар эмнэлгийн удирдлага, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах, зөвлөмж дүгнэлт гаргах, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.1.10 Хорооны ажлыг гүйцэтгэхэд эмнэлгийн эмч мэргэжилтэнг татан оролцуулах;

3.1.11 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар улс, орон нутаг, байгууллагын түвшний хурал, зөвлөгөөн, ярилцлага, сургалтад оролцох, зохион байгуулах.

3.2 Хороо дараах үүрэг гүйцэтгэнэ.

3.2.1 Тухайн эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эмийн жагсаалтыг боловсруулах, батлан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих

3.2.2 Антибиотикийн бодлого болон нянгийн эсрэг эмийн мэдрэг чанарыг тодорхойлсон дүнд үндэслэн нянгийн эсрэг эмийн жагсаалтыг боловсруулах, шинэчлэх, батлуулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх,

3.2.3 Эмнэлэгт антибиограм боловсруулан, тодорхой давтамжтайгаар шинэчлэх, батлуулах, түгээх,

3.2.4 Нотолгоонд суурилсан, нянгийн эсрэг эмийн эмчилгээний удирдамж, заавар зэргийг антибиотикийн бодлоготой уялдуулан боловсруулах, шинэчлэх,

3.2.5 Антибиотикийн бодлогын хэрэгжилтийг хянах, үр дүнг үнэлэх,

3.2.6 Эмийн үйлчилгээний үр дүнг тооцон эмийн хэрэглээг үнэлэх, эмчилгээний болон эдийн засгийн үр ашиггүй эмийн хэрэглээг бууруулах, эмийн үнэ, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хяналт судалгаа хийх, үр дүнг байгууллагын удирдлагад хагас жил тутам тайлагнах;

3.2.7 Тасгуудад хэрэглэж буй нянгийн эсрэг эмийн хэрэглээг үнэлэх, нянгийн , мэдрэг чанарын зүй тогтлыг судлан тандах, үр дүнг эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд тайлагнах;

3.2.8 Эмийн гаж нөлөөг бүртгэн, мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох журмын дагуу гаж нөлөөний мэдээллийг хэлэлцэн, үнэлж Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэх;

3.2.9 Гаж нөлөө үүсгэх өндөр эрсдэлтэй, эмчилгээний индекс багатай эмийн жагсаалтыг эмнэлгийн тусламж үйлчилгээний онцлогтоо тохируулан гаргаж, жагсаалтад орсон эмийн гаж нөлөө илэрсэн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны заавар боловсруулан баталж , мөрдүүлэх;

3.2.10 Эмийн хэрэглээтэй холбоотой тохиолдож болзошгүй эрсдэл, эмчилгээний алдаа дутагдлаас сэргийлэх, түүнийг арилгах арга хэмжээг зохион байгуулах;

3.2.11 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх аргачлал, гарын авлага, удирдамжуудыг боловсруулахад оролцох;

3.2.12 Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, хяналт тавьж ажиллах;

3.2.13 Эмнэлгийн эмч, мэргэжилтэнг улсын бүртгэлд бүртгэгдсэн шинэ эмийн мэдээллээр хангах, эмийн эмчилгээг оновчтой, эдийн засгийн үр ашигтай, үр дүнтэй төлөвлөх чадварыг бий болгох ажлыг зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангах;

3.2.14 Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний талаарх эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, дадлага, хандлагыг системтэй дээшлүүлэх, нянгийн эсрэг эмийн эмчилгээний үндэслэл, жор бичилтийг сайжруулах сургалтыг зохион байгуулах;

3.2.15 Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй болон амбулаториор үйлчлүүлэгчдэд эмийн хэрэглээний талаарх мэдлэг олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах;

Дөрөв. Антибиотикийн дэд хорооны үүрэг

4.1 Антибиотикийн дэд хорооны ахлагч:

4.1.1 Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг удирдан ажиллана,

4.1.2 Эмийн эмчилгээг зохицуулах хорооны гишүүн байна,

4.1.3 Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийн төлөвлөлт, менежментийг хариуцан ажиллах,

4.1.4 Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийн жил тутмын төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих,

4.1.5 Эмнэлгийн тусламж үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулахад оролцох,

4.1.6 Нянгийн эсрэг эмийн хэрэглээг тогтмол хянаж, аудит хийсэн талаар Эмийн эмчилгээг зохицуулах хороо болон эмнэлгийн удирдлагад мэдээлэх,

4.1.7 Дэд хорооны гишүүдийн хамт сургалт, судалгааны ажил хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2 Нян судлаач эмч:

4.2.1 Нян судлалын шинжилгээг хийх багаж, тоног төхөөрөмж, оношлуур зэргийн хүртээмжтэй байлгах талаар эмнэлгийн удирдлагад мэдээлэх,

4.2.2 Антибиограм болон нянгийн тэсвэржилтийн тандалтын мэдээллийг холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтэнд түгээх,

4.2.3 Антибиотикийн мэдрэг чанарын шинжилгээний дүнг мэдээлэх, шинжилгээний хариуг тайлагнах ажлыг хариуцах,

4.2.4 Шаардлагатай тохиолдолд түргэвчилсэн шинжилгээг нэвтрүүлэх,

4.2.5 Олон эмэнд тэсвэртэй нянг эрсдэлт бүлэгт илрүүлэх, хянах, мэдээлэх ажлыг зохион байгуулах,

4.2.6 Бусад шинжилгээтэй харьцуулан таамаг антибиотик эмчилгээ сонгоход шаардлагатай мэдээ, мэдээллийг эмч нарт түгээнэ.

4.3 Антибиотикийн асуудал хариуцсан эм зүйч:

4.3.1 Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийн үйл ажиллагааг ахлан, тэргүүлэх үүрэг гүйцэтгэх,

- 4.3.2 Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх багийн бусад гишүүдтэй эмнэлзүйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд хамтарч ажиллах,
- 4.3.3 Эмнэлзүйн удирдамж, эмийн эмчилгээ болон бусад холбогдох журам, дүрэм боловсруулахад оролцох, шинэ антибиотик эмийн эмчилгээг хянах,
- 4.3.4 Хөтөлбөрийн интервенцид хамрагдах эмчлүүлэгчийг тодорхойлж сонгох,
- 4.3.5 Антибиотик эмийн эмчилгээг зохицуулах, тухайлбал: өргөн хүрээний үйлдэлтэй эмээс явцуу хүрээний үйлдэлтэй эмэнд шилжүүлэх эсвэл эмийн хэлбэрийг өөрчлөх буюу тарилгын эмийн хэлбэрээс уух хэлбэрт шилжүүлэх, шаардлагагүй антибиотикийг зогсоох, хавсарсан эмчилгээний талаар үнэлгээ хийж хянах,
- 4.3.6 Хязгаарлалттай хэрэглэх антибиотикийн жагсаалтыг халдвар судлаач эмч, нян судлаач эмчтэй хамтран батлах,
- 4.3.7 Антибиотикийн хэрэглээ болон тандалтын судалгааг хариуцах. Үүнд:
- 4.3.7.1 Эмнэлгийн антибиотикийн хэрэглээ, зарцуулалт антибиотик эмчилгээний талаар антибиотикийн дэд хороо, эмийн эмчилгээг зохицуулах хороо, эмч нарт эргэн мэдээлэх, мэдэгдэх,
- 4.3.7.2 Удирдамжийн дагуу эмчилгээ хийгдэж буй эсэх,
- 4.3.7.3 Эмийн эмчилгээний алдаа,
- 4.3.7.4 Эмнэлгийн болон үндэсний түвшний тандалтын мэдээ мэдээлэл, тоо баримт гаргах, цуглуулах,
- 4.3.7.5 Эмнэлгийн антибиотик эмийн хэрэгцээ, нөөц бүрдүүлэлтэд шаардлагатай тоо баримт цуглуулж мэдээний сан бүрдүүлэх, тооцоолол хийхэд оролцох,
- 4.3.7.6 Эмнэлзүйн удирдамжийн болон эмчилгээний үр дүн, эмчлүүлэгчийн биеийн байдал сайжирсан эсэх, эдийн засаг, санхүү, нянгийн тэсвэржилтийн байдал, хөдлөл зүйг хянах.

Тав. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайлан мэдээг ирүүлэх

- 5.1 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газрын эмийн эмчилгээг зохицуулах хороо нь эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр дотооддоо гаргаж, тушаалын хавсралтаар баталсан маягтын дагуу бүтэн жилээр нэгтгэн гаргаж, эмнэлгийн тэмдгээр баталгаажуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвд дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор бичгээр болон асуудал хариуцсан мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;
- 5.2 Ор бүхий хувийн эмнэлгүүдийн эмийн эмчилгээг зохицуулах хороо нь эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр дотооддоо гаргаж, тушаалын хавсралтаар баталсан маягтын дагуу бүтэн жилээр нэгтгэн гаргаж, эмнэлгийн тэмдгээр баталгаажуулан харъяа Эрүүл мэндийн газартаа дараа оны 1 дүгээр сарын 15 -ны дотор бичгээр болон холбогдох эмийн мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;
- 5.3 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь эмийн эмчилгээг зохицуулах хорооны нэгтгэсэн дүнг, тайлангийн хамт Эрүүл мэндийн хөгжлийн төвд дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор бичгээр болон асуудал хариуцсан мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;

Зургаа. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны үйл ажиллагааг үнэлэх, зохицуулах

6.1 Эмийн эмчилгээг зохицуулах хорооны үйл ажиллагааг үнэлэх, зохицуулах ажлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтнүүд хариуцан ажиллана. Үүнд:

6.1.1 Хорооны үйл ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн дүгнэх;


6.1.2 Тайлан, мэдээтэй холбоотой шаардлагатай зөвлөмжийг эмнэлэг бүрт мэдээлэх;

6.1.3 Тушаалын хавсралтаар батлагдсан маягтуудын дагуу ирүүлсэн статистик мэдээг нэгтгэн, тухайн жилийн 2 дугаар улиралд багтаан Хүний эмийн зөвлөлийн хуралд танилцуулах;

6.1.4 Хорооноос илрүүлсэн гаж нөлөөний мэдээллийг Хүний эмийн зөвлөлийн Эм судлалын салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, зохицуулалтын арга хэмжээг авах;

6.1.5 Эмнэлгүүдийн эмийн эмчилгээг зохицуулах хороотой хамтран хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 сарын 07 өдрийн тушаалын хоёрдугаар хавсралт



Эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээ


Эмнэлгийн нэр ОН

№	Үзүүлэлт	
1	Нийт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо	
2	Дундаж ор хоног /эмчлүүлсэн хугацаа/	
3	Эмчилгээнд нэг зэрэг хэрэглэсэн эмийн дундаж тоо	
4	Нийт хэрэглэсэн эмэнд антибиотик эмийн эзлэх хувь	
5	Нийт хэрэглэсэн эмэнд тарилгын эмийн эзлэх хувь	
6	Нийт хэрэглэсэн эмэнд зайлшгүй шаардлагатай эмийн эзлэх хувь	
7	Нийт хэрэглэсэн эмэнд илэрсэн гаж нөлөөний тоо	
8	Эмчилгээ оношилгооны удирдамжын дагуу эмчилгээнд хэрэглэсэн эмийн эзлэх хувь	
9	Хэвтэн эмчлүүлэх хугацаанд хэрэглэсэн эмийн дундаж үнэ /1 эмчлүүлэгчид/	
10	Хэвтэн эмчлүүлэх хугацаанд үйлчлүүлэгчийн ар гэрээс авч эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн эмийн тоо	
11	Өвчтөнөөр авчруулж эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн эмийн үнэ	

Эмийн хэрэглээний тооцоо гаргасан:

Нарийн мэргэшил
Албан тушаал

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 сарын 07 өдрийн А/41/19 тушаалын гуравдугаар хавсралт



Эмнэлгийн антибиотик эмийн хэрэглээний талаарх мэдээ


Эмнэлгийн нэр ОН

№	Үзүүлэлт	
1	Нийт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо	
2	Антибиотикт мэдрэг чанар тодорхойлсон шинжилгээний тоо	
3	Эмчилгээнд хэрэглэсэн нийт антибиотик эмийн эзлэх хувь	
4	Нийт хэрэглэсэн антибиотик эмэнд тарилгын эмийн эзлэх хувь	
5	Нийт хэрэглэсэн антибиотик эмэнд илэрсэн гаж нөлөөний тохиолдлын тоо	
6	Нийт хэрэглэсэн антибиотик эмнээс зайлшгүй шаардлагатай эмийн эзлэх хувь	
7	Нэг үйлчлүүлэгчид хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн антибиотик эмийн дундаж тоо	
8	Урьдчилан сэргийлэх зорилгоор антибиотик хийлгэсэн өвчтөний тоо	
9	Нийт хэрэглэсэн антибиотик эмийн эмчилгээний дундаж хугацаа	
10	Антибиотик эмчилгээнд тарилгын хэлбэрээс уух хэлбэр лүү шилжүүлсэн өвчтөний тоо	
11	Нэг үйлчлүүлэгчид хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн антибиотик эмийн дундаж үнэ	

АТС код	Эмийн ОУ-ын нэр	Эмийн худалдааны нэршил	Эмийн хэлбэр	Эмийн тун	Хэрэглэсэн тоо ширхэг
J01GB06	Amikacin- Амикацин		тариа		
J01CA04	Amoxicillin- Амоксициллин		Уух		
J01CA04	Amoxicillin- Амоксициллин		тариа		
J01CR02	Amoxicillin and enzyme inhibitor- Амоксициллин ферментийн хориглогч		Уух		
J01CR02	Amoxicillin and enzyme inhibitor- Амоксициллин ферментийн хориглогч		тариа		
J01CA01	Ampicillin- Ампициллин		Уух		
J01CR01	Ampicillin - Ампициллин		тариа		

J01CE08	Benzathine benzylpenicillin- Бензатин пенициллин		тариа		
J01CE01	Benzylpenicillin- Бензилпенициллин		тариа		
J01DB04	Cefazolin- Цефазолин		тариа		
J01DE01	Cefepime- Цефепим		тариа		
J01DD62	Cefoperazone, combinations- Цефоперазон, нийгмэл найрлагатай		тариа		
J01DD01	Cefotaxime- Цефотаксим		тариа		
J01DE02	Cefpirome- Цефпиром		тариа		
J01DD02	Ceftazidime- Цефтазидим		тариа		
J01DD04	Ceftriaxone- Цефтриаксон		тариа		
J01DC02	Cefuroxime- Цефуроским		Уух		
J01DC02	Cefuroxime- Цефуроским		тариа		
J01BA01	Chloramphenicol- Хлорамфеникол		Уух		
J01BA01	Chloramphenicol- Хлорамфеникол		тариа		
J01MA02	Ciprofloxacin- Ципрофлоксацин		Уух		
J01MA02	Ciprofloxacin- Ципрофлоксацин		тариа		
J01CF02	Cloxacillin- Клоксациллин		Уух		
J01CF02	Cloxacillin- Клоксациллин		тариа		
J01FA01	Erythromycin- Эритромицин		уух		
J01FA01	Erythromycin- Эритромицин		Сукцинат шахмал		
J01FA01	Erythromycin- Эритромицин		тариа		
J01GB03	Gentamicin- Гентамицин		Тариа		
J01DH51	Imipenem and enzyme inhibitor- Имипенем, ферментийн хориглогч		Тариа		
J01MA12	Levofloxacin- Левофлоксацин		Уух		
J01MA12	Levofloxacin- Левофлоксацин		тариа		
J01DH02	Meropenem- Меропенем		Уух		
J01XD01	Metronidazole- Метронидазол		тариа		
J01XD01	Metronidazole- Метронидазол		Уух		
J01FA03	Midecamycin- Мидекамицин		тариа		
J01FA03	Midecamycin- Мидекамицин		Уух		
J01MA14	Moxifloxacin- Моксифлоксацин		тариа		

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09
сарын 07 өдрийн А/41/19 тушаалын
дөрөвдүгээр хавсралт




Антибиотик мэдрэг чанар тодорхойлсон дүн

Эмнэлгийн нэр

..... ОН

№	Үзүүлэлт		
1	Антибиотик мэдрэг чанар тодорхойлсон хүний тоо		
2	Антибиотик мэдрэг чанар тодорхойлсон дүн	Мэдрэг / %/	Мэдрэг бус /%/
3	Пенициллины бүлэг		
4	Макролидын бүлэг		
5	Цефалоспорины бүлэг		
6	Тетрациклины бүлэг		
7	Аминогликозидууд		
8	Карбапенемүүд		
9	Липопептидүүд		
10	Оксазолидон		
11	Бусад		

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 сарын 07 өдрийн А.14/1 тушаалын тавдугаар хавсралт



Эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайлан

Эмнэлгийн нэр.....ОН

Эмийн эмчилгээг зохицуулах хорооны удирдлага, зохион байгуулалтын талаарх товч танилцуулгыг бичих.

№	Үйл ажиллагааны чиглэл	Хийсэн ажил	Хүрсэн үр дүн	Цаашид анхаарах, асуудал дэвшүүлэх санал
1	Эмийн хангамж, хүртээмж			
2	Эмийн чанар, аюулгүй байдал			
3	Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх			
4	Антибиотик болон нянгийн эсрэг үйлчилгээтэй эмийн хэрэглээ хяналт			
5	Эмийн жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангамж			
6	Эмийн эмчилгээний үр дүн, эмийн хэрэглээ, эмийн эмчилгээний чанар, өртөг зардлын талаар хийсэн үнэлгээ болон судалгаа /хийсэн үнэлгээ, судалгааны дүнг хавсаргана/			
7	Эмийн зохистой хэрэглээний мэдээлэл, сургалт, сурталчилгаа			
8	Бусад үйл ажиллагаа			